

Г.ЗАНАБАЗАРЫН НЭРЭМЖИТ ДҮРСЛЭХ УРЛАГИЙН МУЗЕЙН



Музеолог буюу музей судлал гэсэн нэр томъёо анх XIX зууны сүүл үеэс шинжлэх ухааны гүйлгээнд орсон. Дэлхийн улс орон бүрт эрт, эдүгээгийн хүний гараар бүтээгдсэн **дүрслэх урлагийн** сод тууривал бүтээл, уран сайхны сэтгэлгээний гэрч болсон **гоц** гайхамшигт бүтээлүүдийг дэлгэн үзүүлдэг Fine arts museum байдаг.

Монгол оронд 1921 онд **ардын** хувьсгал ялсны дараа явагдсан **улс** орны нийгэм, эдийн засаг, соёлын бүх салбарыг хамарсан шинэтгэл өөрчлөлтийн хүрээнд Монголд анхны музейн үүсэл тавигджээ. Монголын анхны музей нь тэр үеийн тус улсын шинжлэх ухааны төв байгууллага болох Судар бичгийн хүрээлэнгийн харъяанд байгуулагдсан байна. 1921 оны 11-р сарын 22-ны өдөр баталсан Судар бичгийн хүрээлэнгийн 15 зүйл бүхий дүрэмд **“Хүрээлэнгийн газраа дэлхий дахины улсын бичиг судрын сан ба музей хэмээх зүйл бүрийн сонин зүйлийг хурааж олон хүн үзэж танихад тус болгоно”** хэмээн заасан ажээ. Улсын төв музейн урлагийн тасаг нь 1966 онд өргөжин

бие дааж Дүрслэх урлагийн музей байгуулагдаж, **улмаар Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музей болсон түүхтэй.**

Тус музейд хүй нэгдлийн үеийн дүрслэх урлагийн дурсгалаас эхлэн XX зууны Монголын дүрслэх урлагийн түүхэн хөгжил, онцлогийг харуулсан үзмэрийг дэглэн үзүүлж байна.

Музей эд зүйлийг цуглуулах, сэргээн засварлах, дэглэн үзүүлэх, сан хөмрөгт түшиглэн судалгааны ажил явуулах, түүнчлэн үндэсний ба дэлхий нийтийн соёлыг танилцуулж бахархал төрүүлэх, музейн сан хөмрөг түүнд агуулагдаж байгаа мэдээлэл, мэдлэгийг олон нийтэд, бүх насны хүмүүст хүртээх, мэдлэг ба соёлд тэднийг оролцуулахад зэрэг үйл ажиллагааг явуулна.

Музейн боловсролын хөтөлбөрт ажлууд, музейн сан хөмрөгөөс тусгай үзэсгэлэнгүүд, үзэсгэлэн бүрийг каталогизуулах зэрэг ажлуудыг тогтмол зохион байгуулж ажиллаж байна.

Дүрслэх урлагийн музейн үзүүллэгийг шинжлэх ухааны үндэслэл, уран сайхны зохистой шийдэлтэйгээр дэглэн үзүүлж байна. Мөн сан хөмрөгөө түшиглэн үзэсгэлэн тогтмол зохион байгуулж, үзэсгэлэнгийн танхимд ажиллуулна. Музейн судалгаа, сурталчилгааны ном сэтгүүл, дүрс бичлэг зэргийг бэлтгэн гаргаж олон нийт хүн амд зориулсан танин мэдэхүй, сурталчилгааны ажлыг тогтмол зохион явуулж байна.

Манай хамт олон цаашид олон нийтэд чиглэсэн мэдээлэл сурталчилгааны нээлттэй, тав тухтай, соёлч үйлчилгээтэй орчин бүрдүүлэн үзэгчдэд үйлчлэх, мөн ажиллагсдын мэдлэг чадварыг дээшлүүлэхэд онцгой анхааран” Ажилтны хөгжил-байгууллагын хөгжил” гэсэн зарчим баримтлан ажиллана. Нөгөөтэйгүүр музейн үзүүлэг, боловсрол олон нийтийн ажлыг дэлхий нийтийн түвшинд хүргэх талаар онцгойлон анхаарч бусад улсын туршлагыг нэвтрүүлэн **гадаад хамтын ажиллагааг** өргөтгөн ажиллахаар зорилт тавин ажилласаар байна.